



“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”

Эрдэнэ Баян Хөндий алтны төслийн хойд хязгаарыг 2.6 гр/т алттай 81 метр бүхий өрмийн цооногоор үргэлжлүүлэн тэлэв. Үүнээс 17 метр интервал нь 9.2 гр/т алтны агуулгатай байв.

Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот - 2018 оны 7-р сарын 5

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD | MSE:ERDN) нь өөрийн 100% эзэмшдэг, Баян Хөндий алтны төслийн 2018 оны хоёрдугаар улиралд эхэлсэн хайгуулын өрөмдлөгийн ажлын 3-р багц үр дүнг танилцуулахдаа таатай байна.

“Энэ оны 2-р улиралд гүйцэтгэсэн өрөмдлөгийн ажлын сүүлийн багц үр дүн маань Баян Хөндийн хүдэржсэн бүсүүд гүндээ болон суналын дагуу үргэлжилж байгааг баталлаа. Энэ нь цаашид нөөцийн тооцоололд эерэг нөлөө үзүүлэх нь гарцаагүй” хэмээн компанийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэв. Тэрээр үргэлжлүүлэн “Бид Баян Хөндийн анхны нөөцийн тооцооллыг хийх ажлыг эхлүүлсэн. Түүний зэрэгцээ Баян Хөндийг агуулдаг Хөндий алтны дүүрэгт хийж буй хайгуулын ажлууд, Хөндий тусгай зөвшөөрлийн төвийн хэсгийн өрөмдлөг нь ирээдүйд шинэ хүдэржсэн бүсүүдийг нээн илрүүлэх боломж, нөхцлийг бүрдүүлээд байна” гэж танилцууллаа.

Онцлох үр дүн

(План зураг болон хөндлөн зүсэлтийг хавсралтаас харна уу.)

- Өрөмдлөгийн ажлаар хойд Мидфийлд бүсийг зүүн хойд зүгт тэлж, Баян Хөндий алтны системд шинэ, хүдэржилтийн бүс байх боломжтойг тодорхойллоо.
 - BKD-254 цооногт 2.6 гр/т алтны агуулгатай 81 метрийн зузаантай интервал илэрсэн ба үүнээс 17 метр интервал нь 9.2 гр/т алтны агуулгатай байна.
- Мидфийлд бүсийн өрөмдлөгийн ажлаар хайгуулын талбайн зүүн хэсэгт өндөр агуулга бүхий бүс үргэлжилж буйг баталгаажууллаа. Үүнд:
 - 2.8 г/т алтны агуулга бүхий 51.8 метр огтлогдсон ба үүнээс нэг дээжинд 86 г/т хүртэлх алт илэрсэн (BKD-251)
- Баян Хөндийн өрөмдлөгийн ажлын бүх үр дүнг Баян Хөндийн анхны нөөцийн тооцооллыг эхлүүлээд буй RPMGlobal-д хүргүүлсэн.
- Баян Хөндийн тусгай зөвшөөрлийн талбайд эрлийн өрөмдлөгийн ажлыг үргэлжлүүлэн хийсээр байна.

Баян Хөндийн өрөмдлөгийн ажлын тухай

2018 оны 4-р сарын 11-нд эхэлсэн Компанийн 2018 оны 2-р улирлын хайгуулын өрөмдлөгийн ажил нь дараах зорилтуудтай. Үүнд:

Хойд Мидфийлд болон Мидфийлд бүсүүд дэх өндөр ач холбогдол бүхий структурын талбайнуудыг шалгах; Страйкер, Баруун Страйкер, Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүд дэх өрөмдлөгийн цооног хоорондын зайг багасгах; 1.4 км урттай талбайд алтны хүдэржилттэй бүсүүдийг тэлэх боломж бүхий хэтийн төлөвт сонгогдсон талбайнуудыг үргэлжлүүлэн шалгах зэрэг ажлууд багтана.

Өнөөдрийн мэдээгээр нийт 1,799 тууш метр бүхий 9 цооног (BKD-248-ээс BKD-255, мөн сунгалтын нэг цооног)-ийн үр дүнг танилцуулж байна. Компани Баян Хөндий төслийг анх илрүүлсэнээс хойш нийт 42,656 тууш метр өрөмдөөд байгаа ба 2018 онд 4,584 тууш метрийн өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Бүх цооногуудыг 45-85 градусын налуутайгаар өрөмдсөн ба алтны өндөр агуулгатай кварцын судлууд болон хүдэржсэн брекчийг хөндлөн огтлохоор төлөвлөгдсөн.

Өрөмдлөгийн үр дүнгийн тухай

Хүснэгт 1-т дээр дурдсан 9 цооногуудын үр дүнгийн онцлох хэсгүүдийг оруулсан ба үр дүнгийн тайлбарыг мөн хавсаргасан. Хавсралтаас план зураг болон хөндлөн зүсэлтийг харна уу.

Хүснэгт 1. Хойд Мидфийлд бүсийн өрөмдлөгийн ажлын үр дүнгийн онцлох хэсгүүд

Цооногийн дугаар	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (г/т)
BKD-254	102.6	184	81.4 ⁽²⁾	2.59
түүндээ	112	129	17	9.2
түүндээ	112	114	2	50.9
ба	116	117	1	14.7
ба	122	123	1	17.1
BKD-145 (үргэлж)	213	231	18	1.72
түүндээ	216	217	1	21.3

(1) Хүснэгтэнд байх интервалууд нь жинхэнэ зузаан биш болно. Одоогоор хүдрийн системийн хэлбэр болон түүний огторгуйн байршилыг тооцоолох хангалттай өгөгдлийн сан байхгүй байна. Цооногууд нь хойш-баруун хойш зүгт -45-аас -85 градусын уналын өнцөгтэйгөөр өрөмдөгдсөн. Баян Хөндийн хүдэржилт нь дунд зэргийн уналтай (ойролцоогоор 40-50 градусын өнцгөөр баруун урагш унасан байршилтай).

(2) Мэдээлсэн интервалд 141.3-151.1 метрийн гүнд байх 9.8 метр, хүдэржилтийн дараа үеийн дэл судал (дайк) багтсан. Энэ нь дунджаар 0.05 г/т алтнаас ихгүй агуулагатай; энэ дэл судлыг эс тооцвол, 2.92 г/т алтны агуулагатай 71.6 метр огтлогдсон.

Өрөмдлөгөөр 3.96 г/т алтны дундаж агуулгатай 40 метр огтлогдож байсан ба BKD-179 цооногт илэрсэн хүдэржилтийн суналын дагуух үргэлжлэлийг шалгахаар BKD-254

цооногийг өрөмдсөн. ВКD-254 цооног нь 102.6 метрийн гүнээс эхлэх дунджаар 2.59 г/т алтны агуулагатай 81.4 метрийн зузаан хүдэржсэн бүсийг огтолсон ба үүний 17 метр нь дунджаар 9.2 г/т алт агуулж байв. Энэ үр дүн нь Хойд Мидфийлд бүсийн тухайн хэсэгт хүдэржилт болон агуулга үргэлжилж буйг баталгаажуулж байна. Мөн Баян Хөндийн хүдэржилтийн хойд хэсэгт томоохон хэмжээтэй өндөр агуулга бүхий бүс нээгдэх боломжтойг илэрхийлнэ.

ВКD-145 цооног нь 201 метрийн гүнд хүдэржилтийн дараах үеийн сенитийг 12 метр огтолсноор энэ цооногийг хаасан. Гэвч ВКD-145 цооногийн ойролцоо өрөмдсөн цооногийн үр дүнгээс харахад ВКD-145 цооногийн ёроолд огтлогдсон сенит нь томоохон интрузивийн дээд хэсэг биш харин дэл судал байх боломжтой нь тогтоогдсон. Компани үүнийг шалгахад ВКD-145 цооногийг сунган өрөмдсөн. 15 метр сенит өрөмдсөнөөр 43 метр зузаан интерваль бүхий хүдэржсэн түффийг огтолсон ба 272 метрийн гүнд дахин сенитийг огтлох үед цооногийг хаасан. ВКD-145 (Ext) цооног 213 метрийн гүнээс эхлэх дунджаар 1.72 г/т алттай 18 метр зузаан интервалыг огтолсон ба үүнээс нэг метр интервальд 21.3 г/т алт илэрсэн.

Хүснэгт 2. Мидфийлд бүсийн өрөмдлөгийн ажлын үр дүнгийн онцлох хэсгүүд

Цооногийн дугаар	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (г/т)
Мидфийлд бүс				
ВКD-251	19	151.9	132.9	1.44
түүндээ	93	144.8	51.8	2.79
түүндээ	93	94	1	86.2
ба	144	144.8	0.8	11.5
Мидфийлд болон Страйкер бүсийн хооронд				
ВКD-252	72	115	43	0.42
түүндээ	77	83	6	1.05
Ба	164	206	42	1.13
түүндээ	169	171	2	14.0
Баруун Мидфийлд бүс				
ВКD-253	116	125.5	9.5	1.11
ба	162	179	17	1.66

(1) Хүснэгт 1-ийн 1-р тодруулгыг харна уу.

Талбай тэлэлтийн (ВКD-251) цооногоор Мидфийлд бүс дэх баруун хойш болон зүүн хойш чиглэлтэй үндсэн структуруудын огтлолцол дээр илэрсэн алтны өндөр агуулга бүхий хүдэржилтийн үргэлжлэлийг шалгахад төлөвлөсөн. Лабораторийн шинжилгээгээр 19 метрийн гүнээс эхлэх дунджаар 1.44 г/т алтны агуулгатай 132.9 метр зузаан интерваль байгааг баталгаажуулав. Үүний 1 метр нь 86.2 г/т хүртлэх алтны агуулгатай байсан. Энэ үр дүн нь өмнөх өрөмдлөгийн ажлаар илэрсэн агуулга болон хүдэржилтийн үргэлжлэлийг баталгаажууллаа.

ВКD-252 цооногийг Страйкер болон Мидфийлд бүсүүдийн хооронд, өмнөх ажлаар илэрсэн хүдэржсэн өргөн бүс болон өндөр агуулгат нарийн бүсүүдийг үргэлжлүүлэн шалгах

зорилгоор өрөмдсөн. ВКD-252 цооног нь 162 метрийн гүнд дунджаар 1.13 г/т алтны агуулгатай 42 метр зузаан интервалыг огтолсон. Үүнээс 2 метр интерваль нь дунджаар 14.0 г/т алттай байсан. Энэ үр дүн нь хүдэржсэн өргөн бүс болон өндөр агуулгат нарийн бүсүүд Баян Хөндийн алтны системийн энэ хэсэгт үргэлжилж байгааг баталгаажуулж байна.

Мөн өндөр агуулгат хүдэржилт Мидфийлд бүсийн баруун өмнөд буланд үргэлжилж буй эсэхийг шалгахар ВКD-253 цооногийг өрөмдсөн. Лабораторийн хариугаар хүдэржилт нь баруун зүгт үргэлжилж буй нь тогтоогдсон ба энд 1.11 г/т алтны агуулгатай 9.5 метр болон 1.66 г/т алттай 17 метр огтлогдсон.

Хүснэгт 3. Залгаа орших хайгуулын талбайн онцлох хэсгүүд

Цооногийн дугаар	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (г/т)
Баруун Страйкер бүс				
ВКD-248	86	95	9	0.60
ба	130.7	142	11.3	0.42
ВКD-249	67	78	11	0.36
ба	146	148	2	2.02
ба	270	276	6	0.46
ВКD-250	91	110	19	0.58
ба	138	150	12	0.53
ба	242	250.9	8.9	0.42
Зүүн Страйкер бүс				
ВКD-255	126	131	5	0.51

(1) Хүснэгт 1-ийн 1-р тодруулгыг харна уу.

Баруун Страйкер бүсэд өрөмдсөн 3 цооног (ВКD-248, ВКD-249, ВКD-250)-ийн лабораторийн хариугаар 0.36-0.60 г/т алттай 6-19 метрийн зузаан хэд хэдэн бүс байгаа нь тогтоогдсон. Эдгээр үр дүн нь өргөн тархацтай алтны хүдэржилтийн бүс байгааг баталгаажуулж байна.

Бүс нутгийн хайгуул

Сүүлийн жилүүдэд Компани нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хайгуул хийн, хэтийн төлөвтэй 7 талбай бүхий шинэ алтны дүүргийг нээсэн (“Хөндий алтны дүүрэг”). Эдгээр талбайн 2 нь буюу Баян Хөндий, Алтан Нар нь хэтийн төлөв сайн буюу орд болгон хөгжүүлэх боломжтой төслүүд тул 2018 онд ашигт малтмалын нөөцийг нь олон улсын стандартаар тооцоолохоор ажиллаж байна.

Алтан Нар нь Баян Хөндийгөөс хойд зүгт 16 км зайд орших дундаж сульфидтай алт-полиметаллын орд бөгөөд бодит нөөц нь дунджаар 2.8 г/т алттай дүйцэх (AuEq) агуулгатай 452,900 унц, боломжит нөөц нь дунджаар 2.5 г/т AuEq агуулгатай 277,100 унц бөгөөд нийт бодит нөөц нь 5.0 сая тонн (“сая тн”), боломжит нөөц нь 3.4 сая тн хүдэрт агуулагдаж байна. Бодит нөөцөд 317,700 унц алт (дундаж агуулга нь 2.0 г/т алт), 31,600 тонн (“тн”) цайр,

29,000 тн хар тугалга болон 2.35 сая унц мөнгө агуулагдаж байгаа бол боломжит нөөцөд 185,700 унц алт (дундаж агуулга нь 1.7 г/т алт), 23,700 тн цайр, 22,300 тн хар тугалга болон 865,900 унц мөнгө агуулагдаж байна (2018 оны 5-р сарын 10-ны мэдээ).

Одоогоор гүйцэтгэж буй бүс нутгийн эрлийн өрөмдлөгийн ажил нь Баян Хөндийгөөс хойш 3.5 км зайд орших алт-мөнгөний Алтан Сум төсөл дээр хийгдэж байна. Энд 2017 оны 4-р улиралд эрлийн өрөмдлөгийн ажлаар илэрсэн алтны өндөр агуулгатай хэсгүүдэд дараагийн шатны нэмэлт өрөмдлөгийн ажлийг гүйцэтгэж байна. Өмнөх өрөмдлөгийн ажлаар ААD-12 цооногт 70 г/т алтны агуулгатай 2 метр, мөн түүнээс гадна баруун зүгт 300 м зайд орших шинэ талбайг шалгахад 1 метрийн 39 г/т алтны агуулга (ААD-11) бүхий интервалуудыг тус тус тогтоосон.

Компани мөн Алтан Сум төслөөс зүүн зүгт 2.5 км зайд байх Хойд Хөндий алтны хэтийн төлөвт талбайд анхны өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Энэ талбайн хөрсөн дэх алтны аномаль нь 1 км урт үргэлжлэдэг ба анхны чулуун дээжлэлтийн ажлаар кварцын штокверк, гематитийн брекч агуулсан халцедон маягийн кварцын судлуудаас 22 г/т хүртлэх алтны агуулга илэрсэн байдаг. Энд шаврын хувирлаар хүчтэй хувирсан хэд хэдэн талбай тохиолдох ба энэ нь баруун урд зүгт 3.5 км зайд байх Баян Хөндий талбайтай төстэй бөгөөд зүүн хойш чиглэлтэй гол структурын дагуу үргэлжлэн үндсэн кварцын брекчийн бүсийн баруун хойд хэсэг хүрсэн байдаг. Үүнийг өрөмдлөгийн ажлаар шалгах болно.

Компанийн 100% эзэмшдэг алтны төслүүдээс гадна Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн баруун залгаа орших 1,780 га Улаан хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн 51%-г Компани 100% хүртэл эзэмших нөхцөлтэйгөөр худалдаж авсан. Энэ хайгуулын талбайд урьд нь өрөмдлөгийн ажил болон суваг малталтын ажил хийж байгаагүй. Энэхүү талбайд 3 км диаметр бүхий маш өргөн, гүний, порфир төрлийн ордуудад тохиолддог хүчтэй хувирлын бүс оршдог. Компани нь одоогийн байдлаар 2017 оны 4-р улирлаас 2018 оны 2-р улирлын хооронд хийсэн геологи, геофизик болон геохимийн судалгааны үр дүнд тулгуурлан, 2018 оны 3-4-р улиралд уг талбайд анхны өрөмдлөгийн судалгааг гүйцэтгэхээр зорьж байна.

Мөн түүнчлэн Эрдэнэ нь Тек Ресурс Лимитэд компанитай хамтын ажиллагаа ("**Хамтын ажиллагаа**")-г үргэлжлүүлэн Эдрэнгийн террейний порфир болон порфиртой холбоотой хүдэржилтийн хэтийн төлөв бүхий талбайг ялгах, бүс нутгийн эрлийн ажлаа үргэлжлүүлэн, Монгол улсын баруун өмнө хэсэгт хайгуулын хэтийн төлөв бүхий талбай хамтран илрүүлэхээр зорьж байна. Баян Хөндий, Алтан Нар, Алтан Сум, Улаан, Хөвийн Хар болон Зуун Мод төслийн талбайнууд энэхүү хамтын ажиллагаанд хамаарахгүй болно.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Майкл МакДоналд (Michael A. MacDonald) нь Компанийн Хайгуул эрхэлсэн дэд ерөнхийлөгч, мэргэшсэн геосудлаач (P.Geo.) (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэ мэдээлэлд багтсан техникийн мэдээллийг хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн.

Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмт спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic алттай analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд өндөр агуулга бүхий газрын гадаргад ойр Баян Хөндий алтны төсөл, Баян Хөндий төслийн талбайгаас 16 км зайд орших өндөр агуулга бүхий газрын гадаргатай ойр алт-полиметаллын Алтан Нар төсөл, Баян Хөндий төслийн талбайтай залгаа орших зэс-алтны порфирын хайгуулын Улаан талбай, Баян Хөндий төслийн талбайгаас хойд зүгт 3.5 км-т орших өндөр агуулга бүхий алт-мөнгөний Алтан Сум төсөл, хөгжүүлэлтийн эхний шатанд явж буй зэс-мөнгөний порфирын Хөвийн

Хар төсөл, өндөр агуулга бүхий зэс-алтны Номин Тал нээлт, томоохон молибден-зэсийн порфирын Зуун Мод орд зэрэг төслүүдийн хүрээнд 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Үүнээс гадна, Монгол улсын баруун урд зүгт, Транс Алтайн бүсэд Канад улсын Тек Ресурс компанитай хамтарсан бүс нутгийн зэс-алтны хайгуулын үйл ажиллагааг эрхэлж байна. Компани нь Баян Хөндий, Алтан Нар төслүүдийн тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр (“NSR”)-ийг Сэндстормд төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрийг 1% хүртэл бууруулах боломжтой. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч, танилцах боломжтой. Эрдэнэ нь 161,775,791 ширхэг Энгийн хувьцаа, хорогдуулах боломжит 185,951,320 Энгийн хувьцаатай болно.

Урьдчилсан таамаглал



Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш болно. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.


Холбоо барих:

Петер С. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал
Кэн В.МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
Email: info@erdene.com
Вебсайт: www.erdene.com
Твиттер: <https://twitter.com/ErdeneRes>



Bayan Khundii Cross-Section - Looking Northwest Through Midfield Zone



Bayan Khundii Cross-Section - Looking Northwest Through North Midfield Zone

